СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 05

| Д/д | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх | 1.1.АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, сурталчилгааны самбарт байршуулан олон нийтэд хүргэсэн байх | -Баримтжуулсан байх<br>-Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) | Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, сурталчлах зорилгоор Авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан зурагт хуудас, тараах материалыг Сонгинохайрхан дүүргийн Дотоод аудитын албаны алба ёсны цахим хуудасанд байршуулан нийт 380 иргэдэд сурталчилж ажилласан. Мөн "Авлигатай тэмцэх газар", "АТГ-Олон нийтийн төв" пэйж хуудсанд тус албаны 7 албан хаагч нэгдэж, мэдээ мэдээллийг тухай бүр авч байна. | 100.0% |
| | | 1.2.Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх | 2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх | Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах зорилгоор Авлигын эсрэг хууль, мөн Авлигатай тэмцэх газрын түүхэн замнал, онцлог, зорилго зорилт, Авлигатай тэмцэх үнэсний хөтөлбөрийн талаар мөн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлээр хяналт шалгалтаар илэрч буй зөрчил дутагдлын талаар гарын авлага, материал бэлтгэн олон нийтэд сурталчилж ажиллалаа. | 100.0% |
| | | 1.3.Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргаж буй мэдээ мэдээлэл, гарын авлага, тараах материал зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигыг мэдээлэх | Мэдээллийг тухай бүр шинэчлэх | Бэлтгэн гаргасан Авлигын эсрэг хууль, мөн Авлигатай тэмцэх газрын түүхэн замнал, онцлог, зорилго зорилт, Авлигатай тэмцэх үнэсний хөтөлбөрийн талаарх гарын авлага дээр авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлан ажиллалаа. | 100.0% |

14

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 110 дугаарыг оруулан сурталчлах, байгууллагын мэдээллийн самбарт авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах | | | |
| | | 1.4.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх | Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх | Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газраас Авилгатай тэмцэх газартай хамтран дүүргийн төрийн байгууллагуудын албан хаагчдад “Авилга ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сургалт хэлэлцүүлэгийн 2025 оны 06 дугаар сарын 12 ны өдөр зохион байгуулсан бөгөөд сургалтад тус албаны дотоод аудитор М.Гүнчинсүрэн, Б.Дуламжав, Д.Гэрэлт-Од, Г.Жаргалмаа нар хамрагдсан. | 100.0% |
| 2 | Олон нийтийн итгэлийг хүлээсэн авлигаас ангид нийтийг албыг бэхжүүлэх | 2.1.Төрийн албаны хүний нөөцийн удирдлага болон томилгооны ил тод, мэргэшсэн, тогтвортой байдлыг бэхжүүлэх | Сул орон тооны талаарх мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй байршуулсан, албан хаагчдыг мэргэшүүлсэн байдал | Иргэдэд тэгш боломж олгох зорилгоор тус албаны сул орон тооны талаарх мэдээллийг албаны фэйж хуудас болон нийслэлийн төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системээр дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй байршуулан ажилладаг. Мөн тус албаны 4 аудиторыг Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Аудиторын сургалтад хамруулан мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн. | 100.0% |
| | | 2.2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилт | Тус албаны 6 аудитор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд мэдүүлж баталгаажуулан ажилласан. Мөн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг албаны 2024 оны эхний хагас жилийн байдлаар хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж байгаа албан хаагчдаас нийт 72 ашиг сонирхлын зөрчилгүйг мэдэгдсэн хуудсыг гаргуулан авч ажиллалаа. | 100.0% |

15

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2.3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын мэдээллийг нээлттэй мэдээллийн системд байршуулах ажлыг зохион байгуулах | Цахимжуулсан мэдээллийн тоо хэмжээ | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын мэдээллийг нээлттэй мэдээллийн системд байршуулах ажлын хэсгийг албаны даргын 2025 оны А/12 дугаар тушаалаар томилж, үүрэгжүүлсэн. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу shilen.gov.mn цахим системд албаны холбогдох мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар хэрэгжилт 55%-тай байгаа бөгөөд 4 дүгээр улиралд мэдээллээ иж бүрэн байршуулсан болно. | 95.0% |
| 3 | Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | 3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх | -Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх;<br>-Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх<br>-Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах; | Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын алба, Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан “Гэрээний үүрэг, төрөл, онцлог” сэдэвт сургалтад хамрагдан Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар албан хаагчдад зөвлөж ажиллалаа. | 80.0% |
| | | 3.2.“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах | Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх | Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх чиглэлийн дагуу тус албаны чиг үүрэг, зорилго зорилт, төлөвлөгөө тайлан, төсөв санхүү, хүний нөөцийн мэдээлэл нь Нээлттэй мэдээллийн систем, Шилэн дансны нэгдсэн систем, байгууллагын албан ёсны цахим хуудсанд олон нийтэд ил тод нээлттэй байршуулсан болно. | 100.0% |
| | | 3.3.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хяналт шалгалтыг гүйцэтгэх | Хяналт тавьж ажилласан байгууллагын тоо | Сонгинохайрхан дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний болон харъяа нийт 117 байгууллага (орон нутгийн байгууллага 12, орон нутгийн өмчит аж ахуйн | 100.0% |

16

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | тооцоот үйлдвэрийн газар 3, сургууль 29, Насан туршийн суралцахуйн төв 1, цэцэрлэг 71, Хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төв 1), төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй 26 өрхийн эрүүл мэндийн төв, нийт 143 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд сар, улирлаар хяналт шалгалтыг гүйцэтгэж, хяналт шалгалтын тайланг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж ажиллалаа. | |
| 4 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх гм/ | Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх; | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр албан хаагчдын хувийн ашиг сонирхол, харилцаа хандлага, ёс зүйн байдлыг тодорхойлох зорилгоор үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг жил 2 удаа санхүү бүртгэлийн ажилтнуудаас авч дүгнэлт хийж үр дүнг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлан хугацаанд тус албаны үйл ажиллагаа, албан хаагчтай холбоотой гомдол мэдээлэл ирээгүй болно. | 90.0% |
| | | 4.2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний болон харьяа төсөвт байгууллагуудын дотоод хяналтын нэгжийн ажлыг эрчимжүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах | Хяналт тавьж ажилласан байгууллагын тоо | Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний болон харьяа төсвийн нийт 117 байгууллагын 2025 оны дотоод хяналтын нэгжийн төлөвлөгөө, тайланг бүс хариуцсан аудиторууд хүлээн авч, үнэлэлт, дүгнэлт зөвлөмж өгч ажиллалаа. | 100.0% |
| | | 4.3.Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах | Бодитой үр дүнг тооцсон байх | 2025 онд төрийн болон орон нутгийн байгууллагуудын санхүү, бүртгэлийн ажилтнуудын дунд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг 2 удаа явуулж, сэтгэл ханамжийн судалгаанд нийт 128 санхүү, бүртгэлийн ажилтнууд хамрагдлаа. Энэ судалгаагаар тус албанаас цахим орчинд цаг үеэ олсон мэдээлэл түгээдэг, цахим хуудаснаас хэрэгтэй мэдээллээ олж авдаг, албан хаагчдын харилцаа хандлага, ёс зүй, санхүүгийн хяналт | 100.0% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | шалгалт, Дотоод аудитын үйл ажиллагааг судалгаанд оролцогчдын 98.6% нь хууль, тогтоомжийн хүрээнд шударга явагддаг гэж хариулсан байна. | |
| 5 | Байгууллагын удирдлага авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | 5.1.Удирдлагын зүгээс 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах | Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх | Тус албаны Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр баталж, хэрэгжилтийн тайланг хагас бүтэн жилээр гаргаж холбогдох байгууллагад хүргүүллээ. | 100.0% |
| | | 5.2.Байгууллагын дотоод хяналтыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх | Үйл ажиллагаанд удирдлагын санал тусгасан байх | Тус албаны даргын 2024 оны А/18 дугаар тушаалаар Чанарын үнэлгээний багийг 3 хүний, А/19 дугаар тушаалаар Дотоод хяналтын багийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Чанарын болон дотоод хяналтын баг нь гүйцэтгэх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд аудиторуудын хяналт шалгалтын явц байдал, тайланд чанарын үнэлгээ, дотоод хяналт шалгалтыг хийж албан хаагчдад зөвлөгөө зөвлөмж өгч ажилладаг. | 100.0% |
| Гүйцэтгэлийн дундаж хувь | | | | | 97.6% |

ХЯНАСАН:
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА Д.ТӨМӨРБААТАР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
АХЛАХ ДОТООД АУДИТОР Г.ЭНХЗУЛ

5689996 СБТ 23044 9024011262